

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, СОЁЛЫН
САЙД НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны 07 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар А/260/А/391 А/1461 А/260

Улаанбаатар
хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.3, 9.6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2-т заасан “Хүний хөгжлийн бодлого”-ын 2.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 8 дугаар хуралдааны тэмдэглэлийн 1.3-ын 1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд “Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2022-2026)”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Б.Болор-Эрдэнэ), Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга (Л.Цэдэвсүрэн), Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга (С.Оюунбилэг), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга (Г.Өнөрбаяр)-д даалгасугай.


3. Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэх, үйл ажиллагааг ханган ажиллахыг И-Монгол академи УТҮГ (Л.Энхбат), бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийн бүтцийг тодорхойлох, сургалтын агуулга боловсруулахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (М.Итгэл), сургалт зохион байгуулах, сургагч багш бэлтгэх ажлыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), И-Монгол академи УТҮГ (Л.Энхбат)-т тус тус даалгасугай.

4.Төлөвлөгөөний хэрэгжилтэд жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг танилцуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Н.Батхуяг), Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ч.Энх-Амгалан), Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Чимэдлхам), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Д.Чинзориг)-т тус тус үүрэг болгосугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД БӨГӨӨД ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД



СОЁЛЫН САЙД



"БҮХ НИЙТИЙН ЦАХИМ УР ЧАДВАР, ЧАДАМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ" ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололт амжилтад тулгуурлан нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт инновац хийх чадвартай,

№	Зорилт (Objective)	Үйл ажиллагаа (Strategy/Activity)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрэх үр дүн					Хэрэгжүүлэгч байгууллага		Шаардлагатай санхүүжилт (сая төгрөгөөр)	Санхүүжилтийн эх үүсвэр
						2022	2023	2024	2025	2026	Үндсэн	Хамтран		
1	Зорилт 1: Интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, компьютер болон бусад тоног төхөөрөмжийг нийлүүлэх	1.1. Алслагдсан сум, суурин газар, баг, хороод, хотын захдуу газар, зуслангуудад хүргэж буй интернэт үйлчилгээний хүртээмжтэй байдал, хурд, холбогдох тоног төхөөрөмжийн талаарх судалгааг хийж, дэд бүтэц хүрсэн төвийн цэгүүдтэй харьцуулж, зөвлөмж гаргаж, зөвлөмжид тулгуурлан техник технологийн шийдэл боловсруулж, төсөв тооцоог гарган дэд бүтцийг өргөтгөх, Wi-Fi цэгүүдийг нэмэгдүүлэх	судалгааны тоо зөвлөмжийн тоо технологийн шийдэл боловсруулсан баримт бичиг нэмэгдсэн Wi-Fi цэгүүдийн тоо	330 сум суурин газарт шилэн кабелийн сүлжээ татсан. Улаанбаатар хотод утасгүй сүлжээ байгуулах төслийг хэрэгжүүлсэн.	судалгааны тоо 1 зөвлөмжийн тоо - 1 технологийн шийдэл боловсруулсан баримт бичиг- 1 нэмэгдсэн Wi-Fi цэгүүдийн тоог технологийн шийдэл боловсруулсан баримт бичигт тулгуурлана.	1.Алслагдсан сум суурин газар, баг хороод, хотын зах, зуслангийн газруудад хүргэж буй интернэт үйлчилгээний хүртээмж, хурд, тоног төхөөрөмжийн талаар судалгаа хийж, зөвлөмж боловсруулна. 2.Тогтмол ажилладаг үнэгүй Wi-Fi цэгүүдийн тоог нэмэгдүүлэх, ажиллахгүй болсон цэгүүдийг тогтоож, засварлах ажлыг зохион байгуулна.	1.Судалгааны үр дүн, зөвлөмжид тулгуурлан интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлэх техник, технологийн шийдэл боловсруулж, төсөв тооцоог гаргаж, төсөв батлуулна.	1.Алслагдсан сум суурин газар, баг хороод, хотын зах, зуслангийн газруудад хүргэж буй интернэт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлэнэ.	1.Алслагдсан сум суурин газар, баг хороод, хотын зах, зуслангийн газруудад хүргэж буй интернэт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх, Wi-Fi цэгүүд, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.	1.Амьжиргааны түвшин доогуур, орлого багатай өрхүүд төвлөрсөн газар, боловсролын байгууллагууд, соёлын төв, музей, театр урлагийн байгууллагууд, жижиг дунд бизнес эрхлэгчид төвлөрсөн газруудад Wi-Fi цэгүүдийг шинээр бий болгож, нэмэгдүүлнэ.	ЦХХХЯ	Соёлын яам, и-Монгол академи (ИМА), Үндэсний Статистикийн Хороо, ШУТИС, МХТС НҮБ болон бусад Олон улсын байгууллагууд	2200	БНҮҮС Улсын төсөв
2		1.2. Компьютер, бусад цахим тоног төхөөрөмжийн хүртээмжийн талаарх нарийвчилсан судалгаа хийж, зөвлөмж дүгнэлт гаргаж, хэрэгцээтэй зорилтот бүлгүүдэд нийлүүлэх, шилжүүлэх, түрээслүүлэх зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	судалгаа, зөвлөмжийн тоо зорилтот бүлэг болон иргэдийн тоо нийлүүлсэн компьютер, тоног төхөөрөмжийн нэр, тоо	техник, тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг зорилтот бүлгээр гаргаагүй.	судалгаа, зөвлөмжийн тоо - 1 зорилтот бүлгийн тоо 8-аас доошгүй иргэдийн тоо - 100000 нийлүүлсэн компьютер, тоног төхөөрөмжийн нэр, тоог техникийн шийдэлд оруулсан тоонд тулгуурлана.	1.Судалгааны хамрах хүрээг тодорхойлж, цахим төхөөрөмжийн тоо, элэгдэл зэргийг тодорхойлсон байна. 2.Компьютер, тоног төхөөрөмж нийлүүлэх зорилтот бүлгийг тодорхойлсон байна.	1.Тодорхойлогдсон зорилтот бүлгүүдэд компьютер, цахим төхөөрөмж нэмэгдүүлэх арга хэмжээ, аяныг зохион байгуулна. 2.Соёлын төв, музей, театр урлагийн байгууллагуудыг өндөр хурдны шилэн кабелиар холбох талаар судалгаа хийн, ТЭЗҮ боловсруулах	1.Насан туршийн боловсролын төвүүд, сумын төвийн ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл зүйн танхим, номын санг шаардлагатай компьютер, тоног төхөөрөмж, програм хангамжаар үе шаттай хангаж, орон нутгийн иргэд хичээлийн бус цагаар үйлчлүүлэх боломжтой болгох	1.Хувийн хэвшил болон Олон улсын байгууллагуудын хуучирсан төхөөрөмжүүдийг хандивын шугамаар цуглуулах, зорилтот бүлгийн иргэдэд түгээх ажлыг зохион байгуулна.	ЦХХХЯ	БШУЯ, Соёлын яам, ХНХЯ, ШУТИС, МХТС, Их дээд сургуулиуд НҮБ болон бусад Олон улсын байгууллагууд Гадаад дотоодын байгууллагын хамтын ажиллагаа	2500	Улсын төсөв БНҮҮС	

№	Зорилт (Objective)	Үйл ажиллагаа (Strategy/Activity)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрэх үр дүн					Хэрэгжүүлэгч байгууллага		Шаардлагай санхүүжилт (сая төгрөгөөр)	Санхүүжилтийн эх үүсвэр
						2022	2023	2024	2025	2026	Үндсэн	Хамтран		
3	Зорилт 2: Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг тодорхойлох үндэсний нэгдсэн сургалтын платформ хөгжүүлэх, дотоодын болон Олон улсын статистик үзүүлэлтийн уялдааг хангах, цахим хоцрогдлыг арилгах	2.1. Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх сургалтын нэгдсэн платформ хөгжүүлэх	хөгжүүлж, ажиллуулж эхэлсэн платформын тоо	0	1	1.Цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх нэгдсэн платформын хэрэглэгчийн шаардлага, бодлогын даалгаврыг боловсруулах. Энэхүү платформд сургалтын нэгдсэн хөтөлбөр агуулга, иргэний өөрийнхөө цахим ур чадварыг үнэлэх тестийн систем, хөтөлбөрт хамрагдах онлайн болон танхимын сургалт, сургалтыг дүүргэсний эцэст өөрийгөө шалгах тест, шалгалт авах систем, шалгалтын үр дүн, үнэлгээнд суурилан чадамжийн гэрчилгээ олгох систем, судалгаа, статистик үзүүлэлт зэргийг багтаасан байна.	1.Нэгдсэн платформ хөгжүүлэх төсвийг батлуулан, "Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийн нэгдсэн платформ"-ыг хөгжүүлнэ.	1.Нэгдсэн платформд сургалтын агуулга, хөтөлбөрийг анхан, дунд, ахисан түвшинд ангилан оруулах, туршилтын онлайн болон танхимын сургалтыг явуулах, чадамжийн гэрчилгээ олгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	1.Холбогдох судалгаа, статистикийн үзүүлэлтийг нэгдсэн платформд оруулна. 2.Платформын байнгын үйл ажиллагааг хангах ажиллах, эзэмшигчийг тодорхойлон хүлээлгэн өгнө.	1.Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн контент үе шаттай боловсруулж, сургалтын нэгдсэн платформоор дамжуулан нийтийн хүртээл болгох, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээх	ЦХХХЯ	БШУЯ ХНХЯ хувийн хэвшил ИМА	600	Улсын төсөв Олон улсын байгууллага
4		2.2. Цахим ур чадвар, чадамжийг тодорхойлох статистик үзүүлэлтийг тодорхойлох	Цахим ур чадвар, чадамжийг тодорхойлсон статистик үзүүлэлтийн тоо	МХХТ-ийн талаарх өрхийн судалгаа 2021 онд ХХМТГ болон ҮСХ хамтран хийсэн.	3 удаа статистик үзүүлэлт гаргаж нэгтгэсэн байна.	1.Олон улсын цахим ур чадвар, чадамжийн хүрээг тодорхойлон, энэхүү хүрээний тулгуур үзүүлэлтүүдэд суурилан статистик гаргах гол үзүүлэлтүүдийг тодорхойлох, түүвэр судалгаа хийж үр дүнг нэгдсэн платформд нийтэлнэ.		1.Статистикийн үзүүлэлтийг 2 жил тутам гаргаж үр дүнг нийтэлдэг уламжлал тогтоож, тогтмолжуулна.	1.2022, 2024, 2026 онуудын бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийн үзүүлэлтүүдийг хооронд нь харьцуулан, үр дүнг нийтэлнэ.	ЦХХХЯ	Үндэсний Статистикийн Хороо	600	Улсын төсөв	
5		2.3. Цахим ур чадвар, чадамжийн үндэсний статистик үзүүлэлтүүдийг Олон Улсын дижитал ур чадварын индекс үзүүлэлтүүдтэй уялдуулж, Монгол Улсын үзүүлэлтийг үнэн зөв, бодитой, тогтмол гаргадаг болох	Олон улсын дижитал ур чадварын индекс үзүүлэлт нэмэгдсэн байна.	Монгол Улсын иргэдийн тоон бичиг үсгийн чадавх ЮНЕСКО болон ҮСХ хамтран зохион байгуулсан түүвэр судалгаагаар 2018 оны байдлаар 31%-тай байна.	Цахим ур чадварын хувь 50%-д хүрсэн байна.		1.Үндэсний цахим ур чадвар, чадамжийн индекс үзүүлэлтийг Олон Улсын Цахилгаан холбооны байгууллага болон бусад холбогдох байгууллага руу илгээж, Монгол улсын үзүүлэлтийг ахиулна.		1.Монгол Улсын цахим ур чадвар, чадамжийн индекс үзүүлэлт үнэн зөв, бодитой, тогтмол гардаг болох циклийг тогтмолжуулах, Монгол Улсын олон улс дахь түвшнийг ахиулна.	ЦХХХЯ	ОУЦХБ ҮСХ	100	Улсын төсөв	

№	Зорилт (Objective)	Үйл ажиллагаа (Strategy/Activity)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрэх үр дүн					Хэрэгжүүлэгч байгууллага		Шаардлагатай санхүүжилт (сая төгрөгөөр)	Санхүүжилтийн эх үүсвэр
						2022	2023	2024	2025	2026	Үндсэн	Хамтран		
6		2.4. Цахим ур чадвар, чадамжийн Олон Улсын болон дотоодын судалгааны ажлыг нэгдсэн платформд нэгтгэн олны хүртээл болгох	судалгааны ажлын тоо	0	судалгааны ажил 5-аас доошгүй хийгдсэн байна.	-	-	1.Судалгааны ажлыг нэгдсэн платформд оруулна.	1.Судалгааны ажлыг нэгдсэн платформд жил тутам оруулж, судалгааны тоог ахиулна.	1.Судалгааны ажлыг нэгдсэн платформд жил тутам оруулж, судалгааны тоог ахиулна.	ЦХХХЯ	ИМА	100	Улсын төсөв
7	Зорилт 3: Иргэдэд цахим ур чадвар эзэмшүүлэх, мэдээллийн технологийг зохистой, аюулгүй ашиглах хандлагыг төлөвшүүлэх	3.1. Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийн бүтцийг тодорхойлж, боловсруулан сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулах /Digital literacy framework/	нутагшуулж, боловсруулж батлуулсан чадамжийн бүтцийн хүрээний тоо	0	1	1.Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийн бүтцийн хүрээг тодорхойлж, боловсруулна. /Digital literacy framework/	1.ЕБ-ын суурь, бүрэн дунд боловсролын мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөрт санал өгсөн байна.	1.Монгол хүүхдийн сэтгэхүй, онцлогт тулгуурлан цэцэрлэгээс нь ахлах анги хүртэлх хугацаанд цахим ур чадвар олгох агуулга бүхий хөтөлбөртэй болсон байна. /K12 хөтөлбөр/	1.K12 буюу ижил төстэй хөтөлбөрийг нутагшуулан, туршилтаар нэвтрүүлнэ.	1.Нэвтрүүлсэн туршилтын хөтөлбөрийн үр дүнг тооцож, тайлагнана.	ЦХХХЯ, БШУЯ, ИМА	Боловсролын байгууллагууд	150	Улсын төсөв
8		3.2.Бэлтгэл шатны сургалтын хөтөлбөр боловсруулах, түгээх	Улс орон даяар аяныг зохион байгуулсан байна. бүтээсэн сургалтын контентын тоо	0	21 аймагт очиж ажилласан байна.	1.Компьютер, цахим тоног төхөөрөмж болон интернэтийн талаар ерөнхий ойлголт өгөх сургалтын агуулгыг боловсруулж, туршилтын сургалтын контент бүтээн түгээсэн байна. •Ажил мэргэжилтэй холбоотой ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж, туршилт хичээлийг зохион байгуулах •Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадвар, боловсролыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах •Иргэдэд зориулсан код бичиж сурах сургалтын хөтөлбөрийг боловсруулж, туршилт хичээлийг зохион байгуулах •ТАХ-ийн мэдээлэл технологийн ашиглах чадавхыг дээшлүүлэх	1.Цахим ур чадвар, чадамжийн бүтцийн хүрээнд сургалтын хөтөлбөр агуулгыг боловсруулан сургагч багш нарыг бэлтгэнэ. 2.Сургалтын агуулгын хүрээнд контент бүтээн бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх нэгдсэн платформд оруулсан байна.	1.Цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг аян хэлбэрээр улсын хэмжээнд зохион байгуулсан байна. 2.Зорилтот бүлгүүд (алслагдсан сум суурин газрын иргэд, төрийн албан хаагчид)-д хүрч сургалтыг зохион байгуулсан байна.		ЦХХХЯ, БШУЯ, ИМА	Соёлын яам, Боловсролын байгууллагууд, Насан туршийн боловсролын төвүүд Номын сангууд	600	Улсын төсөв	

№	Зорилт (Objective)	Үйл ажиллагаа (Strategy/Activity)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрэх үр дүн					Хэрэгжүүлэгч байгууллага		Шаардлагатай санхүүжилт (сая төгрөгөөр)	Санхүүжилтийн эх үүсвэр
						2022	2023	2024	2025	2026	Үндсэн	Хамтран		
9		3.3. Анхан шатны сургалтын хөтөлбөр боловсруулах, түгээх	Насан туршийн боловсролын анхан шатны сургалтын хөтөлбөр боловсруулсан байна. бүтээсэн сургалтын контентын тоо	0		1. Төрийн зарим үйлчилгээний албан хаагчдыг иргэдэд төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээс үйлчилгээ авах чадвартай болгоход чиглэл өгөх, зүгшрүүлэх сургагч багш нар болгон бэлтгэсэн байна.	1. Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийн бүтцийн хүрээнд анхан шатны суурь мэдлэг, ур чадвар олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулж, туршилтын хичээлийг эхлүүлсэн байна. 2. Төрийн тусгай алба хаагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч, байгаль орчны салбарт ажиллаж байгаа байгаль хамгаалагч, нийслэлийн хорооны албан хаагч нарыг анхан шатны сургалтад хамруулсан байна.	1. Сургалтын агуулгын хүрээнд номын санч, хорооны нийгмийн ажилтан, сайн дурынхныг сургагч багшаар бэлтгэнэ. 2. Анхан шатны сургалтын хөтөлбөр агуулгыг цахим платформд нэгтгэх, видео контентууд бүтээх, цахим болон явуулын сургалтуудыг хийсэн байна.	1. Цахимаар болон танхимаар сургалт зохион байгуулсан байна. 2. "Иргэдэд цахим ур чадвар эзэмшүүлэх, мэдээллийн технологийн зохистой буюу аюулгүй ашиглах хандлагыг төлөвшүүлэх" мэдээллийн технологийн хакатон /Hackathon/ зохион байгуулах	1. Цахимаар болон танхимаар сургалт зохион байгуулсан байна. 2. Эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.	ЦХХХЯ, БШУЯ, ИМА	Соёлын яам, Боловсролын байгууллагууд, Насан туршийн боловсролын төвүүд Номын сангууд, төрийн байгууллагууд	700	Улсын төсөв
10		3.4. Дунд шатны сургалтын хөтөлбөр боловсруулах, түгээх	Насан туршийн боловсролын дунд шатны сургалтын хөтөлбөр боловсруулсан байна. бүтээсэн сургалтын контентын тоо	0	21 аймагт очиж ажилласан байна.	1. Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн чадамжийн бүтцийн хүрээнд дунд шатны хэрэглээ, мэдээллийн аюулгүй байдлын талаар мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулж, туршилтын хичээлийг эхлүүлсэн байна. 2. Цахим орчинд ёс зүйтэй байх хандлагыг төлөвшүүлэх, тоон гарын үсэг хэрэглэх ур чадвар суулгах сургалтын агуулга боловсруулж хэрэгжүүлнэ.	1. Сургалтын агуулгын хүрээнд номын санч, хорооны нийгмийн ажилтан, соёлын байгууллагын ажилтнууд, сайн дурынхныг сургагч багшаар бэлтгэнэ. 2. Дунд шатны сургалтын хөтөлбөр агуулгыг цахим платформд нэгтгэх, видео контентууд бүтээх, цахим болон явуулын сургалтуудыг хийсэн байна.	1. Мэдээллийн технологийг ашиглахдаа эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, бие махбодийн болон сэтгэлзүйн эрүүл мэндэд учрах аюулаас зайлсхийх чадвартай байх, цахим орчинд учирч болзошгүй аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвар олгох (жишээлбэл, цахим гадуурхал) багц сургалтыг зохион байгуулна.	1. Тэргүүлэх салбаруудын бүтээмжийг нэмэгдүүлэхэд мэдээллийн технологийг нэвтрүүлэхтэй холбоотой төрөлжсөн сургалтын багц хөтөлбөр, агуулга боловсруулан тухайн салбарын төрийн албан хаагчдад сургалтыг зохион байгуулсан байна.	ЦХХХЯ, БШУЯ, ИМА	Соёлын яам, Боловсролын байгууллагууд, Насан туршийн боловсролын төвүүд Номын сангууд, төрийн байгууллагууд	700	Улсын төсөв	

№	Зорилт (Objective)	Үйл ажиллагаа (Strategy/Activity)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрэх үр дүн					Хэрэгжүүлэгч байгууллага		Шаардлагатай санхүүжилт (сая төгрөгөөр)	Санхүүжилтийн эх үүсвэр
						2022	2023	2024	2025	2026	Үндсэн	Хамтран		
11		3.5.Ахисан түвшний сургалтын хөтөлбөр боловсруулах, түгээх	Насан туршийн боловсролын ахисан түвшний сургалтын хөтөлбөр боловсруулсан байна. бүтээсэн сургалтын контентын тоо	0	21 аймагт очиж ажилласан байна.	1.Программ хангамж, кодчиллын сургалтын хөтөлбөр, агуулга бэлтгэн, видео контент бүтээж түгээнэ. 2.Их, дээд сургуулийн мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрийг судлах, агуулгыг сайжруулах шийдэл боловсруулан, нэвтрүүлнэ.	1.Контент бүтээх, график дизайн, 3D, аргумент реалити (AR), Виртуал реалити (VR) технологи ашиглах сургалтын хөтөлбөр агуулга боловсруулан түгээнэ. 2.Хиймэл оюун ухаан (AI), их өгөгдөл, Юмсын интернэт (IoT) болон тэдгээрийн хэрэглээний талаар сургалтын агуулга бэлтгэн, видео контент бүтээж түгээнэ. 3.Кибер аюулгүй байдлын талаар багц сургалтын хөтөлбөр агуулга бэлтгэн, видео контент бүтээж түгээнэ.	1.Сургалтын агуулгын хүрээнд номын санч, хорооны нийгмийн ажилтан, сайн дурынхныг сургагч багшаар бэлтгэнэ. 2.Ахисан түвшний сургалтын хөтөлбөр агуулгыг цахим платформд нэгтгэх, цахим болон явуулын сургалтуудыг хийсэн байна. 3.Салбарт ажиллаж буй мэргэжилтнүүдийг өөрийн эзэмшсэн мэргэжлээс гадна хэрэгцээтэй байгаа өөр талбар руу мэргэшүүлэх хөтөлбөрүүдийг боловсруулж, нэвтрүүлэх (өргөн нэвтрүүлэг, үүрэн холбоо, харилцаа холбооны суурь сүлжээ ..гэх мэт)	1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт ажиллаж буй хүний нөөцийн чадавхыг таван жил тутам үнэлдэг тогтолцоог нэвтрүүлнэ. 2.Үнэлгээний үр дүнд тулгуурлан чадавжуулах сургалтын хөтөлбөрт 5 жил тутам хамруулна.	1.Хиймэл оюун ухаан (AI), их өгөгдөл, Юмсын интернэт (IoT) болон тэдгээрийн хэрэглээний талаар багц сургалтын орон даяар зохион байгуулна.	ЦХХХЯ, БШУЯ, ИМА	Соёлын яам, Боловсролын байгууллагууд, Насан туршийн боловсролын төвүүд Номын сангууд	1400	Улсын төсөв Орон нутгийн төсөв
12		3.6.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан цахим ур чадвар, боловсрол олгох	зохион байгуулсан сургалтын тоогоор бүтээсэн сургалтын контентын тоо	0	5-аас доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна.	1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулийн мэдээллийн технологийн хичээлийн одоо байгаа агуулгыг судлах, хичээлийг анги урагшлуулан заах боломжтой эсэхийг судалж, зөвлөмж, шийдэл боловсруулна. 2.Төрийн үйлчилгээг хүргэх ухаалаг утасны аппликэйшныг хэрэглэх цахим ур чадварыг сайжруулах, сургалтын багц агуулга боловсруулах, холбогдох сургалтыг зохион байгуулна. 3.Төрийн байгууллагуудын вэб сайт, аппликэйшнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй байгаа эсэх түвшинг тогтоох үнэлгээ хийнэ.	1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай хэрэгцээт компьютер, дагалдах хэрэгсэл; бусад тоног төхөөрөмж, програм хангамжийн талаарх судалгаа хийн, зөвлөмж боловсруулна. 2.Үнэлгээнд суурилан Вэб контентын хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал 2.0/2.1 (Web Content Accessible Guideline 2.0/2.1) олон улсын зөвлөмжийг бүх төрийн байгууллагын вэб сайтуудад нэвтрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй цахим орчныг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.	1.Зөвлөмжийн дагуу компьютер, тусгай хэрэглээний туслах хэрэгслүүд нийлүүлэх, хэрэгцээт програм хангамжаар хангах аян зохион байгуулна. 2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан цахим ур чадвар, боловсрол олгох сургалтуудыг зохион байгуулна. Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургагч багш бэлтгэн, сургалтын хэрэглэгдэхүүн, ном товхимлыг хүртээмжтэй хэлбэрээр хэвлэнэ.	1.Тэгш хамруулан сургах боловсролын хүрээнд мэдээллийн технологийн хичээлийн агуулгыг сайжруулах хувилбарыг боловсруулна.	1.Брайль бичиг үсэг уншдаг төхөөрөмжүүдийг цахимжуулна. 2.Хараагүй иргэдэд халамжийн сангаас олгодог тусгай хэрэгслийн жагсаалтад дэлгэц уншигч програм бүхий компьютер, тохиромжит гар утас, брайл дэлгэц, брайл мемо гэх мэт төхөөрөмжүүдийг нэмэлтээр оруулна.	ХНХЯ, ЦХХХЯ, БШУЯ	Соёлын яам, Боловсролын байгууллагууд, Насан туршийн боловсролын төвүүд Номын сангууд	2000	Улсын төсөв Олон улсын байгууллага

№	Зорилт (Objective)	Үйл ажиллагаа (Strategy/Activity)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрэх үр дүн					Хэрэгжүүлэгч байгууллага		Шаардлагатай санхүүжилт (сая төгрөгөөр)	Санхүүжилтийн эх үүсвэр
						2022	2023	2024	2025	2026	Үндсэн	Хамтран		
13		3.7.Хүүхдэд зориулсан багц сургалт, арга хэмжээ	зохион байгуулсан сургалтын тоогоор бүтээсэн сургалтын контентын тоо	0	5-аас доошгүй удаа сургалт, арга хэмжээ зохион байгуулсан байна.	1.Хүүхдэд цахим ур чадвар олгох албан бус сургалтын багц хөтөлбөр, сургалт зохион байгуулах. (Анхан, дунд, гүнзгийрүүлсэн шатны сургалтуудад хүүхдийг мөн хамруулах уялдааг ханган ажиллана.)	1.Цахим орчинд хүүхэд өөрийгөө хамгаалах болон дэлгэцийн хамаарлаас сэргийлэх хөтөлбөрүүд бэлтгэн, видео контент бүтээж түгээх	1.Цахим орчинд хүүхэд хамгааллын талаар эцэг эх, багш, нийгмийн ажилтнуудад зориулсан хөтөлбөрүүд бэлтгэн, видео контент бүтээж түгээх			ЦХХХЯ	БШУЯ, Боловсролын байгууллагууд	500	Улсын төсөв Олон улсын байгууллага
14		3.8.Бусад зорилтот бүлгүүд болох амьжиргааны түвшин доогуур иргэд, цэрэг, сүм хийдэд шавилан сууж буй хүүхэд, ахмад настан, өрх толгойлсон эх, эцэг, хүүхэд гэх мэт	зохион байгуулсан сургалтын тоогоор	0	5-аас доошгүй удаа сургалт, арга хэмжээ зохион байгуулсан байна.	-	1.Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг, хороодын ахмад настан, амьжиргааны түвшин доогуур иргэдэд мэдээллийн технологийн суурь чадварыг нэмэгдүүлэх, и-Монгол цахим платформуос төрийн үйлчилгээ авах чадварыг суулгах сургалтыг зохион байгуулна.	1.Монгол Улсын баруун болон хойд бүсийн иргэдэд мэдээллийн технологийн суурь чадварыг нэмэгдүүлэх, и-Монгол цахим платформуос төрийн үйлчилгээ авах чадварыг суулгах сургалтыг зохион байгуулна. Цахим гарын үсгийн хэрэглээг таниулна.	1.Монгол Улсын говийн бүсийн иргэдэд мэдээллийн технологийн суурь чадварыг нэмэгдүүлэх, и-Монгол цахим платформуос төрийн үйлчилгээ авах чадварыг суулгах сургалтыг зохион байгуулна. Цахим гарын үсгийн хэрэглээг таниулна.	1.Монгол Улсын баруун бүсийн иргэдэд мэдээллийн технологийн суурь чадварыг нэмэгдүүлэх, и-Монгол цахим платформуос төрийн үйлчилгээ авах чадварыг суулгах сургалтыг зохион байгуулна. Цахим гарын үсгийн хэрэглээг таниулна.	ЦХХХЯ	Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар Аймаг, сумдын ЗДТГ	600	Улсын төсөв Орон нутгийн төсөв
Нийт төсөв												12,750		